2588



Бүгд Найрамдах Монгол Ард Улсын

Сайд нарын Зөвлөлийн

# ТОГТООЛ

| | | |
|---|---|---|
| 1983 оны I2 дугаар сарын 30-ны өдөр | Дугаар 34I | Улаанбаатар хот |

Гадаад явдлын яамны дүрэм батлах тухай

МАХН-ын Төв Хорооны Улс төрийн Товчооны I983 оны XI дүгээр сарын 25-ны өдрийн 278 дугаар тогтоолыг үндэслэн БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлөөс ТОГТООХ нь:

I. "Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Гадаад явдлын яамны дүрэм"-ийг хавсралтын ёсоор баталсугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан I93I оны есдүгээр сарын I9-ний өдөр БНМАУ-ын Ардын Сайд нарын Зөвлөлийн 48 дугаар хурлаар баталсан БНМАУ-ын Гадаад явдлын яамны дүрмийг хүчингүй болсонд тооцсугай.

БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн дарга — Ж.БАТМӨНХ

БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн Хэрэг эрхлэх газрын дарга — Б.БАДАРЧ

Сайд нарын Зөвлөлийн 1983 оны
341 дүгээр тогтоолоор батлав.

# БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН ГАДААД ЯВДЛЫН ЯАМНЫ ДҮРЭМ

## I. Үндсэн заалтууд

1. БНМАУ-ын Гадаад явдлын яам бол тус улсад социализм байгуулах гадаад таатай нөхцөлийг хангах, дэлхийн социалист системийн орнуудын нэгдэл, нягтралыг бэхжүүлэх, бүх нийтийн энх тайван, аюулгүй байдлыг сахин хамгаалах, нийт улс түмний эв найрамдал, хамтын ажиллагааг хөгжүүлэхэд чиглэсэн МАХН, БНМАУ-ын энх тайванч, интернационалч гадаад бодлогыг хэрэгжүүлэх өдөр тутмын үйл ажиллагааг эрхлэн явуулах төрийн захиргааны төв байгууллага мөн.

2. Гадаад явдлын яам Сайд нарын Зөвлөлийн шууд удирдлагаар үйл ажиллагаагаа явуулна.

3. Гадаад явдлын яам үйл ажиллагаагаа БНМАУ-ын Үндсэн хууль, БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомж, энэ дүрмийг удирдлага болгон олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, хэм хэмжээнд нийцүүлэн явуулна.

4. БНМАУ-ын Ардын Их Хурлаас томилсон сайд Гадаад явдлын яамыг толгойлж, яамны хариуцсан үүрэгт ажлын биелэлтийг БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн өмнө бүрэн хариуцна.

5. Яамны зорилго, үүрэгт ажлыг хэрэгжүүлэхтэй холбогдсон гол чухал асуудлуудыг хамтран хэлэлцэж байх коллеги Гадаад явдлын яаманд ажиллана.

Коллегийн гишүүдийг БНМАУ-ын Сайд нарын Зөвлөл батална. Коллегийг яамны сайд даргална.

6. БНМАУ-ын Сайд нарын Зөвлөл үйл ажиллагааны нь онцлогийг харгалзан Гадаад явдлын яамны бүтэц, орон тоог батална.

7.Гадаад явдлын яам зохих журмаар батлагдсан тамга, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

## П.БНМАУ-ын Гадаад явдлын яамны эрх, үүрэг

Гадаад явдлын яам:

I.Бүгд Найрамдах Монгол Ард Улсыг олон улсын харилцаанд төлөөлж, эрх ашгийг нь хамгаалж, БНМАУ-ын Үндсэн хуульд тодорхойлсон гадаад бодлогын чиг шугамыг хэрэгжүүлнэ.

2.БНМАУ-ын энх тайванч, интернационалч гадаад бодлогын үндсэн зорилтуудыг биелүүлэхийн тулд дор дурдсан чиглэлээр санал, арга хэмжээ боловсруулж хэрэгжүүлнэ.Үүнд:

а/Зөвлөлт Холбоот Улс, социалист хамтын нөхөрлөлийн бусад оронтой ах дүүгийн найрамдал, хамтын ажиллагаа, харилцан туслах харилцааг гүнзгийрүүлэн хөгжүүлэх, эдгээр оронтой БНМАУ-ын гадаад бодлогын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, дэлхийн социалист системийн нэгдэл, нягтралыг бэхжүүлэх;

б/Үндэсний болон нийгмийн эрх чөлөөний төлөө улс түмний тэмцэлд дэмжлэг үзүүлэх, чөлөөлөгдсөн орнуудтай нөхөрсөг харилцаа хөгжүүлэх;

в/энх тайвнаар зэрэгцэн орших зарчмыг олон улсын харилцаанд бататгахад тус дөхөм үзүүлэх, уг зарчмын үндсэн дээр нийгмийн өөр өөр байгуулалтай орнуудтай хэвийн харилцаа тогтоон хөгжүүлэх;

г/бүх нийтийн энх тайван, аюулгүй байдлыг бэхжүүлэх, зэвсэглэлээр хөөцөлдөхийг зогсоох, зэвсэг хураахад чиглэсэн БНМАУ-ын олон улсын үйл ажиллагааг өргөжүүлэн идэвхжүүлэх.

3.БНМАУ-ын олон талт дипломат үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлнэ.Үүнд:

а/Нэгдсэн Үндэстний Байгууллага, түүний системийн байгуул-

лагуудад БНМАУ-ыг улс төр, нийгэм, эдийн засгийн асуудлаар төлөөлж, эдгээр байгууллагын төлөөлөгчидтэй хэлэлцээ хийнэ;

б/олон улсын Засгийн газар хоорондын байгууллагуудад БНМАУ гишүүнээр элсэх, тэдгээрийн үйл ажиллагаанд оролцох талаар санал, арга хэмжээ боловсруулж хэрэгжүүлнэ;

в/олон улсын Засгийн газар хоорондын байгууллагуудын шугамаар зохиогдож буй олон улсын хурал, зөвлөлгөөн, уулзалтад БНМАУ оролцохтой холбогдсон ажлыг хариуцна.

4.БНМАУ-ын соёлын гадаад харилцааны бодлогыг төлөвлөн зохицуулж, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч байна.

5.БНМАУ-ын эдийн засгийн гадаад харилцааг хэрэгжүүлэхэд тус дэхэм үзүүлнэ.

6.Олон улсын байдалд дүн шинжилгээ хийж, БНМАУ-ын гадаад бодлогын цаг үеийн болон хэтийн зорилтыг боловсруулж хэрэгжүүлэхэд социалист хамтын нөхөрлөлийн орнуудтай зохицуулалт хийж байна.

7.Гадаад суртал нэвтрүүлгийн талаар санал боловсруулж, энэ салбарт төлөвлөсөн арга хэмжээг хэрэгжүүлэхэд оролцоно.БНМАУ-ын социалист ололт амжилт, гадаад улс төрийн бодлого, үйл ажиллагааг сурталчлах хэрэгт өөрийн улсын хэвлэл, мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллана.

8.БНМАУ-ын тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг хангахтай холбогдсон асуудлууд, тухайлбал улсын хил хязгаарын асуудлаар хийх хэлэлцээ болон бусад төрлийн ажилд оролцоно.Хилийн шугамыг тогтоох болон хилийн дэглэмийн тухай асуудлаар гэрээ хэлэлцээр байгуулж, тэдгээрийг биелүүлэх арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэхэд оролцоно.

9.БНМАУ-ын консулын албаныг эрхлэн явуулахын тулд:

а/БНМАУ-ын харьяатын тухай хууль тогтоомжийн дагуу

5



БНМАУ-ын иргэн болох, иргэнээс гарахтай холбогдсон асуудлыг шийдвэрлэхэд оролцоно;

б/БНМАУ-ын нутаг дэвсгэрт оршин суугаа гадаадын иргэдийн эрх, үүргийг тус улсын дотор дагаж мөрдөж байгаа хууль тогтоомжийн дагуу тодорхойлох, уг эрх, үүргийг хангах явдалд холбогдох байгууллагуудад тус дөхөм үзүүлж байна;

в/дээд байгууллагаас олгосон бүрэн эрхийн үндсэн дээр консулын харилцааны талаар гадаад орнуудтай гэрээ хэлэлцээр байгуулж, биелэлтийг нь хангаж байна;

г/хилийн чанад дахь БНМАУ-ын байгууллага, иргэдийн эрх ашиг, өмч хөрөнгийг хамгаалах асуудлыг эрхэлнэ;

д/гадаад паспорт, виз болон БНМАУ-д буцах үнэмлэх олгох асуудлыг эрхэлнэ.

10.БНМАУ-аас байгуулах олон улсын гэрээний талаар дор дурдсан үүргийг гүйцэтгэнэ.Үүнд:

а/улс төр, соёлын харилцааны асуудлаар олон улсын гэрээ хэлэлцээрийн төсөл боловсруулж БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчид, Сайд нарын Зөвлөлд оруулж байна.Дээрх байгууллагуудаас олгосон бүрэн эрхийн үндсэн дээр мөн асуудлаар гэрээ хэлэлцээр байгуулна;

б/БНМАУ-ын олон улсын гэрээ хэлэлцээрийн биелэлтийг хангахад оролцож, тэдгээрийг хэрхэн дагаж мөрдөж байгаад хяналт тавина;

в/БНМАУ-ын олон улсын гэрээ хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулах, хугацааг нь сунгах, тэдгээрийг цуцлахтай холбогдсон санал боловсруулж холбогдох байгууллагад өргөн мэдүүлж байна;

г/БНМАУ-аас бусад улс болон Засгийн газар хоорондын байгууллагуудтай байгуулсан хоёр талт болон олон талт гэрээ хэлэл-

цээрийн жинхэнэ эхийг, хэрэв тухайн гэрээ хэлэлцээрт өөрөөр заагаагүй бол бүртгэн хадгална.

II.БНМАУ-ын гадаад харилцааны холбогдолтой хууль тогтоомжийн биелэлтийг хангаж улс, хоршоолол, олон нийтийн байгууллагуудаас түүнийг хэрэгжүүлэхэд тус дөхөм үзүүлнэ.

I2.Гадаад харилцааны үйл ажиллагаатай холбогдсон хууль тогтоомжийг боловсронгуй болгох талаар санал боловсруулж эрх бүхий байгууллагуудад өргөн мэдүүлж байна.

I3.БНМАУ-ын төрийн ёслолын ажлыг эрхлэн хариуцна.

I4.БНМАУ-ын яам, бусад байгууллагаас өөрсдийн гадаад харилцааны асуудлаар дээд байгууллагад шийдвэрлүүлэхээр оруулж байгаа асуудлын төсөлд санал өгнө.

I5.БНМАУ-ын гадаад бодлогын зорилгыг хэрэгжүүлэх талаар яам, бусад төв байгууллага, орон нутгийн төрийн захиргааны байгууллагаас явуулж байгаа үйл ажиллагааг чиглүүлэн зохицуулах бөгөөд энэ зорилгоор шаардагдах материал, тайлан, илтгэлийг тэднээс гаргуулан авч байна.

I6.БНМАУ-ын олон улсын гэрээ хэлэлцээр, түүнчлэн гадаад харилцааны бусад чухал баримт бичгийг хэвлэн нийтлэх асуудлыг эрхэлнэ.

I7.БНМАУ-ын гадаад харилцааны улсын архивын ажлыг эрхлэн хариуцна.

I8.Дипломат албаны улс төр, зохион байгуулалтын ажлыг боловсронгуй болгох, уг ажилд тэргүүн туршлага нэвтрүүлэх арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж байна.

I9.Гадаад харилцааны боловсон хүчнийг бэлтгэх, давтан сургах ажлыг эрхлэн гүйцэтгэнэ.

20.БНМАУ-ын дипломат албаны хилийн чанад дахь байгууллагуудыг байгуулах, татан буулгах талаар санал боловсруулж, тэдний үйл ажиллагааг чиглүүлэн удирдаж байна.

21.Гадаад улсаас БНМАУ-д суугаа дипломат төлөөлөгчийн болон консулын газрууд, олон улсын байгууллагын төлөөлөгчдийн эрх хэмжээг өөрийн оронд дагаж мөрдөж байгаа хууль тогтоомж, олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмын үндсэн дээр тодорхойлон тогтоож, уг эрх хэмжээг сахин биелүүлэх явдлыг хангана.

22.БНМАУ-ын байгууллага, албан тушаалтнаас гадаадын байгууллагууд, тэдгээрийн төлөөлөгчидтэй харилцах талаар тогтоосон журмыг хэрэгжүүлэхэд хяналт тавьж байна.

23.БНМАУ-аас гадаад улсад суугаа дипломат төлөөлөгчийн болон консулын газруудтай харилцахын тулд холбооны янз бүрийн хэрэгсэл, түүний дотор нууцалсан цахилгаан, дипломат элчийг ашиглана.

24.Гадаад явдлын яамны сайд дор дурдсан эрх эдэлнэ.Үүнд:

а/зохих удирдамжийн дагуу тусгайлсан бүрэн эрхийн үнэмлэх бичиггүйгээр гадаад улс, олон улсын байгууллагын төлөөлөгчидтэй хэлэлцээ хийж, олон улсын гэрээ хэлэлцээрт гарын үсэг зурах;

б/БНМАУ-ын дипломат төлөөлөгчийн газруудын тэргүүн нарыг томилох, эгүүлэн дуудахтай холбогдсон санал боловсруулж эрх бүхий байгууллагад оруулж байх;

в/БНМАУ-ын хэргийг хамаарагч, консулыг тохоон томилсон захидал, патент олгох, гадаад улсын хэргийг хамаарагч, консулыг тохоон томилсон захидал, патентыг хүлээн авч экзекватурыг консулуудад олгож байх;

г/дээд байгууллагын шийдвэрийн үндсэн дээр олон улсын гэрээ хэлэлцээр байгуулах, хурал, уулзалтад оролцох БНМАУ-ын

төлөөлөгчдөд бүрэн эрхийн үнэмлэхийг зохих журмын дагуу олгож байх;

д/дипломат болон консулын аппаратын ажилтан нарт өөрийн эрх хэмжээний дотор дипломат цол олгож байх;

е/БНМАУ-ын хууль тогтоомжийг үндэслэн тэдгээрийг биелүүлэхийн тулд эрх хэмжээнийхээ асуудлаар тушаал, удирдамж гаргаж байх.

25.Хилийн чанад дахь БНМАУ-ын дипломат төлөөлөгчийн болон консулын газрууд Гадаад явдлын яамны системд багтах бөгөөд эрх бүхий байгууллагаас баталсан дүрмийн дагуу Гадаад явдлын яамны өдөр тутмын удирдлагын дор үйл ажиллагаагаа явуулна.

_____oOo_____